



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 16 өдөр

Дугаар А/180

Улаанбаатар хот

“Шугаман эргүүл, Хар цэг” нөлөөллийн
арга хэмжээ хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн, нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэх зорилгоор “Шугаман эргүүл, Хар цэг” нөлөөллийн арга хэмжээг 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 15-ын өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулсугай.

2.Арга хэмжээнд зарцуулах төсвийг хавсралтаар баталж, шаардагдах 2,998,040 (Хоёр сая есөн зуун ерэн найман мянга дөх) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

3.Арга хэмжээг чанар үр дүнтэй зохион байгуулж, санхүүгийн тайлан, холбогдох баримтыг арга хэмжээ дууссанаас хойш ажлын 5 өдөрт багтаан тайлагнахыг Цагдаагийн хэлтсийн Замын цагдаагийн хэсэг (Цагдаагийн дэд хурандаа Д.Билгээ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

АЖИЛ 2024 он ажил захирамж

112320044

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 09 сарын 18-ны өдрийн 4/1 дугаар
захирамжийн хавсралт



“ШУГАМАН ЭРГҮҮЛ, ХАР ЦЭГ” НӨЛӨӨЛЛИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ \
ХҮРЭЭНД ШААРДАГДАХ ШАТАХУУНЫ ТӨСӨВ

Д/д	Төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн зардал	Нийт зардал
1	Шатахуун	Литр	1244	2410	2,998,040
Нийт					2,998,040